



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭМЗЭГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, НЭВТРЭЛТИЙН ШАЛГАЛТ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Монгол Улсын хөгжлийн банкны 2024 оны бараа ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан банкны кибер аюулгүй байдлын эмзэг байдлын үнэлгээ, нэвтрэлтийн шалгалт хийлгэх ажлын хүрээнд дараах ажлын даалгаврыг боловсруулан хүргүүлж байна. Үүнд:

- Банкны кибер аюулгүй байдлын эмзэг байдлын үнэлгээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам нийцүүлэн хийж, зөвлөмж дүгнэлт гаргах.
- Мэдээллийн технологийн систем, дэд бүтцийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдалтай холбоотой эрсдэлүүдийг илрүүлэх, үнэлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээний зөвлөмж гаргах.
- Нэвтрэлтийн шалгалт, эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх цар хүрээ, нарийвчилсан ажлын төлөвлөгөөг захиалагчтай эцэслэн тохиролцон ажлыг эхлүүлнэ.
- Мэдээллийн аюулгүй байдлын нэвтрэлтийн шалгалт, эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх цар хүрээнд дараах зүйлсийг зайлшигүй багтаана:
 - Өнөөгийн байдалд бие даасан бодит үнэлгээ өгөх,
 - Эмзэг сул байдал, цоорхойг илрүүлж арилгах арга замыг тодорхойлох,
 - МАБ-ын эрсдэлээс учрах хохирлыг багасгах,
 - Нэвтрэлт, танилт, баталгаажуулалтыг үнэлэх,
 - Логийн удирдлагын хяналт хийх, үнэлэх,
 - Байгууллагын үндсэн систем дээр нэвтрэлтийн шалгалт хийх,
 - Нэвтрэлтийн шалгалтыг автомат болон гар аргаар гэсэн хоёр аргыг хослуулан хийх,
 - Вэбсайт, API сервисийн мэдээллийн аюулгүй байдлын нэвтрэлтийн шалгалтыг хийх
 - Физик аюулгүй байдлыг үнэлэх
 - Сүлжээний аюулгүй байдал
 - Серверийн аюулгүй байдал
 - Мэдээллийн технологийн дэд бүтцийн хамгаалагдсан байдлын шинжилгээ хийх
- Кибер аюулгүй байдлыг эрсдэлийн чиглэлээр хариу арга хэмжээ тодорхойлох, эмзэг байдлын дэлгэрэнгүй мэдээлэл, засварлах алхмуудын мэдээлэл, зөвлөмж мэдээлэл өгөх,
- Гүйцэтгэсэн ажлаас олж авсан байгууллагын мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах баталгаа гаргаж, гэрээ байгуулан ажиллах,
- Хийгдэх ажлын хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд доголдол үүсгэхгүйгээр ажлыг гүйцэтгэх,
- Мэдээллийн аюулгүй байдлын, кибер аюулгүй байдлын эрсдэлийн хариу арга хэмжээний сургалтыг холбогдох мэргэжилтнүүдэд хийх,

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, нэвтрэлтийн шалгалт хийх системүүд:

№	Төрөл	Систем
1		Core banking system security
2	System/Server Security	Database security
		Active Directory

3		Email server
4		Endpoint
5		Web servers
6		Physical, Virtual servers
8		API
9		Firewalls
10		Internet/LAN/WAN, DMZ, Intranet
11		VPN audit, Network design architecture
12	Network Security	Remote access
13		External connections
14		Antivirus system and update/patch management
15		Wireless (BYOD)
16		SMB
17	Authentication and Access control	Authentication for remote users (VPN, IPSec)
18		Password policy, Kerberos, NTLM

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- Ажил гүйцэтгэх баг нь 3 ба түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүд тухайн байгууллагад сүүлийн 6 сар тасралтгүй ажилласан үндсэн ажилтан байна.
- Төслийн хугацааны 50-с доошгүй хувьд МУХБ-ны байранд ажиллах.
- Багийн голлох гишүүн CISSP эсвэл OSCP сертификаттай байх.
- Багийн бусад гишүүд CISA, CEH, PenTest+, OSEP, OSWE, CPENT олон улсын сертификатуудын аль нэгийг зээмийсэн байх.
- Сүүлийн нэг жилийн хугацаанд ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх.
- Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 25 хоногт багтаан дараах тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэн ирүүлнэ. Үүнд:
 - Кибер аюулгүй байдлын эмзэг байдлын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан
 - Мэдээллийн системүүдэд хийсэн нэвтрэлтийн шалгалтын тайлан /систем тус бүрээр/
 - Нэгдсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний зөвлөмж.

Дээрх техникийн тодорхойлолтын дагуу ажил гүйцэтгэх байгууллагыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу 2024 оны 11-р сарын 30-нд багтаан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж өгнө үү.